

Golomt Capital[®]

ДЭЛХИЙН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**

2025.11.03

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Баасан гарагийн байдлаар S&P 500-ийн 64% нь ашгийн тайлангаа гаргасан бөгөөд тэдний 83% нь шинжээчдийн хүлээлтээс давсан үзүүлэлттэй байжээ.
- Талууд нэг жилийн хугацаатай худалдааны маргааныг түр зогсоох тохиролцоонд хүрсэн.
- Холбооны Нөөцийн Сан бодлогын хүүг буурууллаа.
- АНУ Хятадын худалдааны маргаан зөөлөрч болзошгүй гэсэн өөдрөг хандлага өсөлтийг дэмжсэн ч эдийн засгийн өсөлт саарна гэсэн болгоомжлол илүү нөлөөлөв.
- Дэлхийн банкны мэдээлснээр, Хятадын өрхийн хэрэглээний хэмжээ ДНБ-ий ердөө 40 орчим хувийг эзэлж байгаа нь дэлхийн дундаж болох 56%-аас үлэмж доогуур үзүүлэлт юм.

S&P 500 индексийн 2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
Дундаж	6,678

Таамагласан ханшид хүрсэн.
Дээд таамаглал **7,000** байна





АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.10.27-11.02

III УЛИРЛЫН АШГИЙН ТАЙЛАНГААР ЗАХ ЗЭЭЛ ИДЭВХЖИЖ БАЙНА

АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өнгөрсөн долоо хоногт холимог байдалтай хаагдлаа. Том индексүүд өсөлт үзүүлсэн бол жижиг индексүүд буурав. Хиймэл оюун ухаанд чиглэсэн зардал үргэлжлэн нэмэгдэж байгаа учраас мега технологийн компаниудын өсөлтөөр технологийн Nasdaq Composite индекс гол индексүүдийг тэргүүлэв. Гэсэн хэдий ч зах зээлийн ерөнхийдөө сул байсан бөгөөд S&P 500 индекс өссөн ч 11 салбарын 7 нь уналттай байв.

S&P 500 компанийн гуравны нэгээс илүү нь тайлангаа нийтэлсэн бөгөөд тэдний дунд “Гайхамшигт долоо” (Magnificent Seven) хэмээх томоохон технологийн таван компани багтжээ. FactSet-ийн мэдээллээр Баасан гарагийн байдлаар S&P 500-ийн 64% нь ашгийн тайлангаа гаргасан бөгөөд тэдний 83% нь шинжээчдийн хүлээлтээс давсан үзүүлэлттэй байжээ. “Гайхамшигт долоо”-гийн ашгийн мэдээлэлд хөрөнгө оруулагчдын хариу янз бүр байв. Microsoft, Apple, Meta Platforms-ийн хувьцаа тайлангийн дараа буурсан бол Amazon болон Alphabet өсөв. Үүнээс гадна NVIDIA-ийн хувьцаа өсөж, компанийн зах зээлийн үнэлгээ долоо хоногийн дунд үеэр 5 их наяд ам.долларыг давсан нь дэлхийн анхны ийм түвшинд хүрсэн компани боллоо.

АНУ, Хятад худалдааны дайнаа түр зогсоох тохиролцоонд хүрэв. Энэ долоо хоногийн гол анхаарал АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп болон БНХАУ-ын дарга Си Жиньпин нарын худалдааны харилцааны талаарх уулзалт дээр төвлөрөв. Талууд нэг жилийн хугацаатай худалдааны маргааныг түр зогсоох тохиролцоонд хүрсэн бөгөөд үүнд АНУ Хятадын бараанд ногдуулсан татварыг бууруулах, Хятад ховор металлын экспортоо зогсоохоо болих, мөн АНУ-ын шар буурцаг болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн худалдан авахаа сэргээх зэрэг багтаж байна. Хэдийгээр тохиролцоо харьцангуй даруухан байгаа ч урт хугацаанд худалдааны дайн дахин сэргэх эрсдэлтэй хэвээр байна.

Холбооны Нөөцийн Сан бодлогын хүүг буурууллаа. Өнгөрсөн долоо хоногийн бас нэгэн гол үйл явдал нь Холбооны Нөөцийн Сангийн (ХНС) аравдугаар сарын мөнгөний бодлогын хурал байв. Лхагва гарагт төв банк бодлогын хүүгээ 25 суурь нэгжээр (0.25%) бууруулж, 3.75–4.00% хүрээнд тогтоосноо мэдэгдсэн нь зах зээлийн хүлээлттэй нийцэв. Гэхдээ хоёр бодлого тодорхойлогч санал зөрөлдөв — Захирлын зөвлөлийн гишүүн Стивен Миран 50 суурь нэгжийн бууралтыг дэмжсэн бол Канзас-Сити бүсийн ХНС-ийн Ерөнхийлөгч Жеффри Шмид хүүг өөрчлөхгүй байхыг санал болгожээ. Энэ нь инфляц зорилтот түвшнээс өндөр, хөдөлмөрийн зах зээл сулран буй нөхцөлд бодлого боловсруулагчдын дунд үзэл бодлын зөрүү нэмэгдэж байгааг харууллаа.

Хурлын дараа ХНС-ийн дарга Жером Пауэлл хөрөнгө оруулагчдын дунд гарч буй дахин хүүг бууруулах талаар таамаглалд хандан арванхоёрдугаар сарын хурлаар дахин хүү бууруулах “урьдчилан тогтоогдсон зүйл биш” гэж мэдэгдэв. Тэр мөн засгийн газрын түр зогсолтын улмаас эдийн засгийн өгөгдөл хомс байгаа тул бодлого боловсруулагчид илүү болгоомжтой байр суурь баримтлах магадлалтайг дурдсан байна.



Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.10.27 – 11.02

БНХАУ-ЫН ТЕХНОЛОГИЙН САЛБАР ӨСЧ БАЙНА.

БНХАУ-ын дотоодын хөрөнгийн зах зээл энэ долоо хоногт холимог байдлаар өндөрлөлөө. АНУ Хятадын худалдааны маргаан зөөлөрч болзошгүй гэсэн өөдрөг хандлага өсөлтийг дэмжсэн ч эдийн засгийн өсөлт саарна гэсэн болгоомжлол илүү нөлөөлөв. FactSet-ийн мэдээлснээр, дотоодын CSI 300 индекс 0.43%-иар буурч, Шанхайн нийлмэл индекс 0.11%-иар өслөө.

Харин Хонг Конгийн Hang Seng индекс 0.97%-иар унасан байна. Эдийн засгийн бодлогын дэмжлэг сул байгаа нь хөрөнгө оруулагчдын итгэлийг сулруулав. БНХАУ-ын удирдагчдын дээд түвшний хуралдаан эдийн засгийн бодлогын шинэ дэмжлэг зарлаагүй нь урт хугацааны өсөлтийн гарахгүй гэсэн таамгийг нэмэгдүүлэв. Коммунист намын дээд албан тушаалтнуудын дөрвөн өдрийн хурлын (дөрөвдүгээр бүгд хурал) дараа засгийн газар “дотоод эрэлтэд тулгуурласан, хэрэглээгээр хөтлөгдсөн эдийн засгийн хөгжлийн шинэ загвар” хэрэгжүүлэхээ амласан талаар Bloomberg төрийн хэвлэлээс эш татан мэдээлэв.

Хэдийгээр шинжээчид Бээжингийн хэрэглээг дэмжих чиг баримжааг эерэг гэж үзсэн ч бодит зорилтот түвшин, тухайлбал ДНБ-д эзлэх өрхийн хэрэглээний тодорхой хувь тогтоогоогүй нь хүлээлтэд хүрсэнгүй. Дэлхийн банкны мэдээлснээр, Хятадын өрхийн хэрэглээний хэмжээ ДНБ-ий ердөө 40 орчим хувийг эзэлж байгаа нь дэлхийн дундаж болох 56%-аас үлэмж доогуур үзүүлэлт юм.

Golomt_Capital created with TradingView.com, Nov 03, 2025 10:48 UTC+8

Hang Seng Index Futures - 1h · HKEX O25,996 H26,087 L25,937 C26,055 +58 (+0.22%) +149 (+0.58%)



Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS WHISPERS										Most Anticipated Earnings Releases										
for the week beginning October 27, 2025																				
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday		Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday		
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	
KDP Keurig Dr Pepper	CLS Celestica	SOFI SoFi	ENPH ENPHASE	VZ verizon	META Meta	LLY Lilly	AMZN amazon	XOM ExxonMobil												
CRI carter's	NXPI NXP	UNH UNITEDHEALTH GROUP	BE Bloomenergy	BA BOEING	MSFT Microsoft	MRK MERCK	AAPL Apple	CVX Chevron												
SIFY sify	CAR avis budget group	PYPL PayPal	STX SEAGATE	CVS CVS Health	GOOGL Alphabet	CMCSA COMCAST	COIN coinbase	ABBV abbvie												
DEA Easterly Government Properties	RMBS Rambus	UPS ups	ONEK ONEOK	CAT CATERPILLAR	CMG CHIPOTLE	RBLX ROBLOX	RDDT reddit	CNI CN												
BMRC Bank of Marin	WM WASTE MANAGEMENT	GLW CORNING	VI VISA	FI fiserv.	CVNA CARVANA	OWL BLUE OWL	WDC Western Digital	LYB lyondellbasell												
RVTY revvity	CDNS cadence	HSBC HSBC	BKNG BOOKING HOLDINGS	CNC CENTENE	NOW servicenow	INSM Insmid	MSTR Strategy	LIN Linde												
BOH Bank of Hawaii	WHR Whirlpool	RCL Royal Caribbean Group	EA Electronic Arts	ETSY Etsy	SBUX Starbucks	PWR QUANTA SERVICES, INC.	ROTT I O T	CHTR Charter Communications												
DQ DAQO NEW ENERGY	CR CRANE	JBLU jetBlue	NGD newgold	ADP ADP	MLB mercado libre	COMM COMMSCOPE	RKT ROCKET Companies, Inc.	CL COLGATE-PALMOLIVE												
BCBP BCB Bank	NUE NUCOR	BHI D-R HORTON	CAKE The Cheesecake Factory	FLEX flex	SFM SPROUTS FARMERS MARKET	EPD Enterprise Products Partners LP	NET CLOUDFLARE	CBQE C boe												
ARLP ALLIANCE TECHNOLOGY PARTNERS LP	AMKR Amkor Technology	W Mondelēz International	MDLZ Mondelēz International	KHC Kraft Heinz	AEM AGNICO EAGLE	AAP Advance! Auto Parts	ROKU ROKU	CVE cenovus												

http://eps.sh/cal © 2025 Earnings Whispers

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS WHISPERS										Most Anticipated Earnings Releases										
for the week beginning November 03, 2025																				
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday		Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday		
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	
CIFR Cipher Mining	PLTR Palantir	UBER Uber	AMD AMD	NVO Novo Nordisk	HOOD Robinhood	CELH CELSIUS	TTD theTradeDesk	CEG Constellation												
ONM onsemi	HIMS hims hers	SHOP shopify	ANET ARISTA	NOV Novo Nordisk	APP APPROVIN	QBT D:WAVE	OPEN Opendoor	DBS 1&1 DIBS												
BRKB Berkshire Hathaway Inc.	NVTS Navitas	SPOT Spotify	SMCI SUPERMICR	U unity	IONQ IONQ	COP ConocoPhillips	IREN Iris Energy	WEN Wendy's												
FUBO fubo TV	BWXT BWXT	UUUU EF ENERGY FUELS	ALAB AsteraLabs	HUM Humana	AMC amc	BCE BCE	MP MP MATERIALS	CGC CANOPY GROWTH												
FRPT freshpet	GOOY GOODYEAR	HUT HUT 8	BYND BEYOND MEAT	DOCN DigitalOcean	QCOM Qualcomm	VST VISTRA ENERGY	SOUN SoundHound	AXL AMERICAN AXLE & MANUFACTURING												
BRKR BRUKER	CLX The Clorox Company	PFE Pfizer	MARA MARATHON	CCJ Cameco	BROS DUTCH BROS	OSCR OSCAR	DKNG DRAFT KINGS	AU ANGLO-AUSLIANT												
BNTX BIOTECH	FN fabrinet	BP bp	KINROSS KINROSS	AES aes	FIG Figma	AZN AstraZeneca	NUSC NUSCALE	BAM Bankfield Asset Management												
AXSM axsome	FANG DIAMONDBACK ENERGY	RACE RACE	AXON AXON	RXRX Recursion	ARM arm	DDOG DATADOG	INOD Innodata	FLR FLUOR												
IDXX IDEXX LABORATORIES	VRTX VERTEX	SWK Vital	UPST Upstart	JCT Johnson Controls	SNAP Snap Inc.	WBD WARNER BROS. DISCOVERY	ACHR ARCHER	FUN Six Flags Entertainment Corporation												
LQDA Liquidia	SRPT SAREPTA	SWK Stanley Black & Decker	CAVA CAVA	FVRR fiverr.	DUOL duolingo	ASP aspens aerogels	ABNB airbnb	DK Duke Energy												

http://eps.sh/cal © 2025 Earnings Whispers